

“ГЕРМЕС ЦЕНТР” ХУВЬЦААТ КОМПАНИ

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН 2019 ОНЫ
ЭЭЛЖИТ ХУРЛЫН МАТЕРИАЛ**

Улаанбаатар хот, “Гермес центр” ХК-ийн байранд

2020 оны 03-р сарын 20-ны өдөр 15.00 цагт

“ТЕРМЕС ЦЕНТР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН 2019 ОНЫ

ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

№	Хэлэлцэх асуудал	Хугацаа	Хэлэлцүүлэгч	Хуудасны дугаар
1	Компанийн 2019 оны бизнесийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-өөс гаргасан дүгнэлт	10 минут	Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг	3 - 8
2	Компанийн 2019 оны аудитаар баталгаажсан санхүүгийн тайланд хийсэн компанийн ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт	10 минут	Аудитын хорооны дарга Д.Туяа	9 - 12
3	Компанийн 2018 оны ногдол ашгийг хуваарилж тараасан тухай мэдээлэл, 2019 оны ногдол ашгийг хуваарилсан болон 2020 оны ногдол ашгийн тухай	10 минут	ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн	13 - 14
4	Компанийн ТУЗ-ийн болон Гүйцэтгэх захирлын цалин урамшуулал, зардлын төсвийн тухай	10 минут	ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн	14 - 15
5	Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд болон тэдгээрийн эзэмшилд байгаа хувьцааны тухай	5 минут	ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн	15
6	Компанийн 2020 оны үйл ажиллагааны зорилтын тухай	5 минут	Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг	16

“ГЕРМЕС ЦЕНТР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН

2019 ОНЫ ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал нь 2020 оны 03-р сарын 20-ны өдрийн 15.00 цагаас “Гермес центр” ХК-ийн төв байрны хурлын танхимд эхэлж, 16:50 цагт дуусна.

№	Хэлэлцэх асуудал	Хугацаа	Хэлэлцүүлэгч	Хурлын шийдвэр
1	Хувьцаа эзэмшигчид хурлын танхимд цуглах	5 минут	Хурал зохион байгуулах комисс	
2	Хурлын тэргүүлэгчийг сонгосон тухай	5 минут	ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн	Хурлын тэмдэглэлд оруулах
3	Хурлын тооллогын комиссын дүнг танилцуулах	5 минут	Тооллогын комисс	Тогтоолоор батлах
4	Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийн тухай	10 минут	Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг	Хурлын тэмдэглэлд оруулах
	Санал шүүмжлэл	5 минут	Хувьцаа эзэмшигчид	
5	Компанийн 2019 оны аудитаар баталгаажсан санхүүгийн тайланд хийсэн компанийн ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт	10 минут	Аудитын хорооны дарга Д.Туяа	Хурлын тэмдэглэлд оруулах
	Санал шүүмжлэл	5 минут	Хувьцаа эзэмшигчид	
6	Компанийн 2018 оны ногдол ашгийг хуваарилж тараасан тухай мэдээлэл, 2019 оны ногдол ашгийг хуваарилсан болон 2020 оны ногдол ашгийн тухай	10 минут	ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн	Хурлын тэмдэглэлд оруулах
	Санал шүүмжлэл	5 минут	Хувьцаа эзэмшигчид	
	Хурлын завсарлага	10 минут	Хуралд оролцогсод	
7	Компанийн ТУЗ-ийн болон Гүйцэтгэх захирлын цалин урамшуулал, зардлын төсвийн тухай	10 минут	ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн	Тогтоолоор батлах
	Санал шүүмжлэл	5 минут	Хувьцаа эзэмшигчид	
8	Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд болон тэдгээрийн эзэмшилд байгаа хувьцааны тухай	5 минут	ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн	Хурлын тэмдэглэлд оруулах
	Санал шүүмжлэл	5 минут	Хувьцаа эзэмшигчид	
9	Компанийн 2020 оны үйл ажиллагааны зорилтын тухай	10 минут	Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг	Хурлын тэмдэглэлд оруулах
	Санал шүүмжлэл	5 минут	Хувьцаа эзэмшигчид	

“ГЕРМЕС ЦЕНТР” ХК-ИЙН 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ТУЗ-ӨӨС ГАРГАСАН ДҮГНЭЛТ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

“Ая тухыг эрхэмлэгч” уриатай манай “Гермес центр” хувьцаат компани нь өнгөрсөн 2019 онд барилгын материалын худалдааны төвийн үйл ажиллагааг явуулахдаа

- Нэгдүгээрт : Худалдан авагчдын эрх ашгийг дээдэлж, ая тухтай үйлчилж
- Хоёрдугаарт : Түрээслэгчдийн эрх ашгийг дээдэлж, тэднийг ажиллах нөхцлөөр хангаж
- Гуравдугаарт : Ажиллагсдынхаа эрх ашгийг хамгаалж, нийгмийн асуудлыг шийдвэрлэж
- Дөрөвдүгээрт : Хувьцаа эзэмшигчдийн нэгж хувьцааны өгөөжийг нэмэгдүүлж ажиллалаа.

Компани 2019 онд батлагдсан хөрөнгө оруулалтын төсөв, орлого зарлагын төлөвлөгөөний хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд :

- Худалдааны төвийн захиргаа нь давхардсан тоогоор 200 гаруй түрээслэгч аж ахуйн нэгж, иргэдтэй түрээсийн гэрээ байгуулан ажилласан. Худалдааны төвийн түрээслэгчдийг даатгалд бүрэн хамруулсан. Түрээслэгчдэдээ сар бүр тогтмол албан захидал хүргүүлж, харилцан ойлголцож, хамтран ажиллаж ирлээ.
- Түрээслэгчдийн дунд арилжааны банк, даатгалын компани, татварын байгууллага, онцгой байдлын хэлтэстэй хамтран уулзалт өдөрлөг, сургалт семинарыг зохион явуулж ажиллалаа. Үүнд : ХХБанк, ХААН банк, Голомт банк, Капитрон банк, Монгол даатгал компани, Миг даатгал, Соёмбо даатгал гэх зэрэг болно. Мөн арилжааны банкууд манай худалдааны төвийн түрээслэгчдэд 20-с 30 сая төгрөг хүртэлх бизнесийн зээлийг барьцаагүй олгодог болсон. Баянгол дүүргийн Онцгой байдлын хэлтэстэй хамтран гамшгийн үед зарлан мэдээллийн дохиогоор ажиллах болон галын аюулгүй байдлын сургалт дадлагыг нийт түрээслэгч, ажиллагсдын дунд зохион байгуулсан. Баянгол дүүргийн 4-р хорооны цагдаагийн албатай хамтран хулгай, залилан, гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх талаар сургалт зөвлөмжийг түрээслэгчдэд өгч ажиллалаа.
- Худалдааны төвийн өдөр тутмын үйл ажиллагааны хүрээнд хийгддэг жижиг болон урсгал засвар, цэвэрлэгээ үйлчилгээний ажлуудыг тогтмол хийж гүйцэтгэсэн.
- Батлагдсан хөрөнгө оруулалтын төсвийн хүрээнд худалдааны төвийн “А” корпусын 1, 2-р давхруудад 4 ширхэг, гадна талбайд 2 ширхэг хяналтын камер, 1 ширхэг хяналтын дэлгэц, 1 ширхэг камерын бичигчийг шинээр суурилуулж, мөн оффисын 3 ажилтны компьютер, 9 ширхэг хурлын сандал зэргийг шинэчилж худалдан авахад нийт 10.5 сая төгрөг зарцууллаа.
- Худалдааны төвийн мэдээллийн самбарын мэдээ, мэдээллийг сар бүр тогтмол шинэчилж, хууль эрх зүйн болон бусад ач холбогдолтой мэдээллээр худалдан авагч, түрээслэгч, ажиллагсдыг хангаж ажилласан.
- Компанийн бүтэн жилийн тайланд аудитын “Цэсб аудит” ХХК-иар хяналт шалгалтын ажлыг хийлгэж, дүгнэлтийг гаргуулсан.
- Компанийн тухай хууль, бусад холбогдох хууль, эрх зүйн заавар журмын дагуу компанийн үйл ажиллагаа, санхүүгийн тайланг МХБирж, Санхүүгийн зохицуулах хороонд цаг хугацаанд нь хүргүүлж, МХБирж болон өөрийн компанийн цахим хуудсанд байршуулан олон нийтэд мэдээлж ирлээ.

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

1. Компанийн санхүүгийн үндсэн үзүүлэлтийн тухай : Компанийн нийт хөрөнгө 8 401.6 сая төгрөг бөгөөд үүнээс :

- Эргэлтийн хөрөнгө 1 874.2 сая төгрөг
- Үндсэн хөрөнгө 4 238.9 сая төгрөг
- Биет бус хөрөнгө 2 288.5 сая төгрөг
- Эзэмшигчийн өмч хөрөнгө 7 854.3 сая төгрөг
- Татварын дараах цэвэр ашиг 820.0 сая төгрөг байна.

2. Татвар төлөлтийн тухай :

Компани 2019 онд татварын байгууллагад нийтдээ 435.3 сая төгрөгийн татварыг төлсөн. Үүнд:

1. ААН-ийн ОАТатварт 89.8 сая төгрөг
2. НДШимтгэлд сая төгрөг 62.2
3. Ажиллагсдын цалингаас суутгасан хувь хүний ОАТатварт 21.0 сая төгрөг
4. НӨАТатварт 127.7 сая төгрөг
5. ҮХЭХАТатварт 48.2 сая төгрөг
6. Ногдол ашгийн татварт 74.6 сая төгрөг
7. Газрын төлбөрт 11.8 сая төгрөг

3. Орлогын үр дүнгийн тухай :

Компани 2019 онд нийтдээ 1 652.5 сая төгрөгийн орлоготой ажилласан. Жилийн эцсийн дүнгээр орлогын нийт дүн төсөвлөсөн 1 606.5 сая төгрөгийн орлогын дүнтэй харьцуулахад 103.0%-ийн биелэлттэй байна.

4. Зардлын тухай :

Компани 2019 онд 740.8 сая төгрөгийн зардал гаргасан болно. Зардлын төлөвлөгөө 772.4 сая төгрөг байсантай харьцуулахад төлөвлөгөөний биелэлт 95%-ийн биелэлттэй гарсан. Компанийн хэмжээгээр зардлыг төсөвлөснөөс 31.6 сая төгрөгөөр хэмнэж ажилласан.

5. Ашгийн тухай

Компани 2019 оны эцэст 820.0 сая төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан. Ашгийн төлөвлөгөө 750.7 сая төгрөг байсантай харьцуулахад ашгийн төлөвлөгөөг 109%-иар буюу 69.3 сая төгрөгөөр давуулан биелүүлж ажилласан. Компани нь нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийн төлөвлөгөөг дараах байдлаар биелүүлсэн. Үүнд :

- 2019 оны нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийн төлөвлөгөө 9 төгрөг 56 мөнгө байсан бол санхүүгийн тайлангаар нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийн хэмжээ 10 төгрөг 44 мөнгө болж, төлөвлөгөөг 9%-иар давуулан ажилласан.

Манай компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь гүйцэтгэх удирдлагын багийн 2019 онд хийж гүйцэтгэсэн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг сайшааж тэмдэглэсэн.


Компанийн 2015 - 2019 он хүртэлх сүүлийн 5 жилийн эдийн засгийн ерөнхий судалгааг шинэчлэн гаргасныг хувьцаа эзэмшигч та бүхэнд танилцуулж байна.

Санхүүгийн үзүүлэлт


төгрөг


№	Үзүүлэлт	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он
1	Эргэлтийн хөрөнгө	1,403,086,689.58	1,541,179,226.10	1,678,326,249.34	1,721,276,038.37	1,874,201,189.91
2	Эргэлтийн бус хөрөнгө	7,035,735,803.31	6,861,584,941.56	6,805,624,589.59	6,677,378,101.86	6,527,354,400.69
3	Нийт хөрөнгө	8,438,822,492.89	8,402,764,167.66	8,483,950,838.93	8,398,654,140.23	8,401,555,590.60
4	Нийт өр төлбөр	219,610,530.09	209,455,277.50	198,987,075.45	213,651,174.42	206,660,096.80
5	Эзэмшигчдийн өмч	8,219,211,962.80	8,193,308,890.16	8,284,963,763.48	8,185,002,965.81	8,194,895,493.80
6	Борлуулалтын орлого	1,494,879,283.52	1,367,696,294.36	1,334,591,010.34	1,389,183,726.83	1,449,256,652.85
7	Нийт орлого	1,569,335,970.52	1,489,906,907.10	1,490,397,917.45	1,572,606,312.34	1,652,538,682.76
8	Нийт зардал	830,946,635.87	817,376,753.65	774,988,602.67	789,189,311.26	832,528,421.60
9	Нийт ашиг	820,420,575.30	750,829,448.23	794,898,101.23	870,464,204.26	911,677,442.26
10	Цэвэр ашиг	738,389,334.65	672,530,153.45	715,409,314.78	783,417,870.81	820,010,261.16
11	EPS /Нэгж хувьцаанд ногдох ашиг/	9.40	8.56	9.11	9.97	10.44
12	PE /Үнэ ашгийн харьцаа/	13.04	19.84	15.59	14.04	12.45
13	ROE /Хувьцаат капиталын өгөөж/	0.09	0.08	0.09	0.10	0.10
14	BV /Нэгж хувьцаанд ногдох дансны үнийн харьцаа/	1.23	1.70	1.42	1.40	1.30

Нийт хөрөнгө /сая.төг/



Нийт орлого, нийт зарлага, цэвэр ашиг /сая.төг/





Хувьцааны ханшийн өөрчлөлт

Компанийн нэгж хувьцааны анхны ханш 2008 онд 100 ₮ байсан бол 2019 онд нэгж хувьцааны ханш 130 ₮ болсон бөгөөд дараах графикаар хувьцааны ханшийн өөрчлөлтийг харуулав.



2019 оны байдлаар нэгж хувьцаа зах зээл дээр дундажаар 130 төгрөгөөр арилжаалагдаж эзэмшигчдийн хөрөнгө 1.3 дахин өссөн байна.

Хувьцааны зах зээлийн үнэлгээ


"Гермес Центр" ХК нь Монголын хөрөнгийн бирж дээр 2 дугаар ангиллын компанид багтдаг бөгөөд 2019 оны 12 дугаар сарын байдлаар зах зээлийн үнэлгээ 10.2 тэрбум төгрөг болсон байна.

Ногдол ашгийн өгөөж

"Гермес центр" ХК нь Монголын хөрөнгийн бирж дээрх хамгийн идэвхитэй ногдол ашиг тараадаг компаниудын нэгэн бөгөөд хувьцаа эзэмшигчдэдээ 2008 оноос эхлэн ногдол ашиг тарааж ирлээ.

2008-2019 онуудад тараасан ногдол ашгийг дараах графикаар харуулав.

2008-2019 онд тараасан ногдол ашиг /сая.төг/



Гүйцэтгэх удирдлагын бүрэлдэхүүн

1. Гүйцэтгэх захирал: Б.Оюунцэцэг
2. Нягтлан бодогч: О.Энхтуяа
3. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга: Д.Эрдэнэсүрэн

Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн

1. ТУЗ-ийн дарга: Д.Оюунсүрэн
2. ТУЗ-ийн ердийн гишүүд: Б.Оюунцэцэг
Д. Алтанчимэг
Ц.Түвшинжаргал
Н.Мөнхзул
Б.Амарсанаа
3. ТУЗ-ийн хараат бус гишүүд: Д.Туяа
Н.Батсайхан
Б.Алтангэрэл

ТҮРЭЭСИЙН ТАЛБАЙН ҮНЭ ТАРИФ /₮/

№	Талбайн нэр	Хэмжих нэгж	Огноо/Түрээсийн үнэ тариф				
			2016	2017	2018	2019	2020
1	1-р давхрын павильон	м.кв	21 000	20 000	20 000	20 000	20 000
2	С давхрын павильон	м.кв	18 000	17 000	17 000	18 000	20 000
3	2-р давхрын павильон	м.кв	18 000	17 000	17 000	18 000	20 000
4	Оффис үзүүлэнгийн талбай	м.кв	18 000	17 000	17 000	18 000	20 000
5	Лангуу	ш	150 000	150 000	150 000	150 000	200 000

Жич: 2020 онд эхний 1, 2-р саруудад түрээсийн төлбөрт 10%-ийн хөнгөлөлт үзүүлнэ.



“ЦЭСБ-АУДИТ” ХХК

УБ дахь оффес: ЧД 03-р хороо, Төмөрчний гудамж;
“Эрдэнийн тойрог” ХХК-ийн байрны 01-р давхар, 108 тоот;
Утас: 99099605; 99019203, Ш/хаяг-erkaa0315@yahoo.com

2020 / 01 / 24 № 202 / 04

**“ ГЕРМЕС ЦЕНТР ХК-ИЙН
УДИРДЛАГАД ”**

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Дүгнэлт

Бид “ Гермес центр ” ХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болгосон санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлангууд, нэмэлт тодруулгыг багтаасан санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь материаллаг асуудлаар Монгол Улсын холбогдох хууль, дүрэм, журмын дагуу үнэн зөв толилуулагдсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэсэн бөгөөд уг стандартын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа “Аудиторын үүрэг хариуцлага” гэсэн хэсэгт харуулсан. Бид энэхүү аудитын ажилд хамаарах ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бус ажиллаж, бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж бид үзэж байна.

Бусад мэдээлэл

Компанийн татварын тайлан болон газар эзэмших эрхтэй холбоотой бүртгэл болон мэдээлэл нь бидэнд хамааралгүй болно. Энэ талаар бид өөрсдийн үзэл баримтлалаа илэрхийлж байсан болно. Удирдлага нь бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээлэлд хамааралгүй болно.

Санхүүгийн тайлантай холбоотойгоор компанийн удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтын талаарх хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайлан гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан боддох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Аудиторын үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан ба алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүнгүүд болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэдэг. Сонгосон горимууд нь аудиторын үнэлэмж, түүний дотор залилан эсвэл алдаанаас шалтгаалсан санхүүгийн тайлан дахь материаллаг алдаатай тайлагналын эрсдэлийн үнэлгээнээс хамаардаг. Эдгээр эрсдэлийн үнэлгээг хийхдээ аудитор нь тухайн байгууллагын дотоод хяналтын үр өгөөжийн талаар дүгнэлт гаргах зорилго тавилгүйгээр, тухайн нөхцөл байдалд тохиромжтой аудитын горимуудыг тодорхойлохын тулд, санхүүгийн тайлангуудыг байгууллага бэлтгэж үнэн зөв толилуулахтай хамаатай дотоод хяналтыг авч үздэг. Түүнчлэн аудитаар тухайн хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн зохистой байдал болон тооцооллын ул үндэслэлийг үнэлж, мөн санхүүгийн тайлангуудын нийт толилуулгыг үнэлдэг.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Ч.ЦЭРЭННАДМИД

" ГЕРМЕС ЦЕНТР" ХК

Аж ахуйн нэгжийн нэр

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2019 оны 12-р сарын 31-ны өдрөөрх

ҮЗҮҮЛЭЛТ	ТОДРУУЛГА	2018.12.31	2019.12.31
Мөнгө ба түүнтэй адилтгах	1	1,611,116,277.62	1,771,526,972.31
Дансны авлага		-	-
Татвар, НДШ-ийн авлага	2	-	-
Бусад авлага		100,139,625.95	93,389,622.95
Бараа материал	3	9,975,291.80	9,284,594.65
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	4	44,843.00	-
Эргэлтийн хөрөнгийн дүн		1,721,276,038.37	1,874,201,189.91
Үндсэн хөрөнгө		4,388,882,101.86	4,238,858,400.69
Биет бус хөрөнгө	5	2,288,496,000.00	2,288,496,000.00
Урт хугацаат хөрөнгө оруулалт		-	-
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		6,677,378,101.86	6,527,354,400.69
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		8,398,654,140.23	8,401,555,590.60
Дансны өглөг		737,000.00	-
Татварын өр		28,181,138.93	30,571,484.90
НДШ-ийн өглөг	6	-	-
Урьдчилж орсон орлого		15,929,478.63	4,682,937.35
Бусад богино хугацаат өр төлбөр		168,803,556.86	171,405,674.55
Богино хугацаат өглөгийн дүн		213,651,174.42	206,660,096.80
Урт хугацаат өр төлбөр		-	-
Нийт өр төлбөрийн дүн		213,651,174.42	206,660,096.80
Эзэмшигчийн өмч			
Хувьцаат /өмч/		7,854,300,100.00	7,854,300,100.00
Эздийн өмчийн бусад хэсэг	7	-	-
Хуримтлагдсан ашиг(алдагдал)		330,702,865.81	340,595,393.80
Эздийн өмчийн дүн		8,185,002,965.81	8,194,895,493.80
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН		8,398,654,140.23	8,401,555,590.60

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

БҮРТГЭЛ ХЯНАЛТЫН
ИТГЭМЖЛЭГДСЭН
БАЙГУУЛЛАГА-2
"ЦЭСБ-АДИТ" ХХК

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

2019 оны 12-р сарын 31-ны өдрөөрх

ҮЗҮҮЛЭЛТ	ТОДРУУЛГА	2018.12.31	2019.12.31
Борлуулалтын орлого	8	1,389,183,726.83	1,449,256,652.85
Борлуулалтын өртөг		-	-
Нийт ашиг /алдагдал/		1,389,183,726.83	1,449,256,652.85
Хүүний орлого	9	182,922,085.51	202,988,591.38
Бусад орлого		500,500.00	287,000.00
Борлуулалт маркетингийн зардал			-
Ерөнхий ба удирдлагын зардал	10	702,142,977.84	735,860,450.50
Санхүүгийн зардал			-
Бусад зардал	11		5,000,790.00
Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз (гарз)	12	869.76	6,438.53
Бусад ашиг (алдагдал)			-
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)		870,464,204.26	911,677,442.26
Орлогын татварын зардал	13	87,046,333.45	91,667,181.10
Татварын дараах ашиг (алдагдал)		783,417,870.81	820,010,261.16
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг			-
Тайлант үеийн цэвэр ашиг		783,417,870.81	820,010,261.16
Бусад дэлгэрэнгүй орлого			-
Орлогын нийт дүн		783,417,870.81	820,010,261.16
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг		9.97	10.44

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

БҮРТГЭЛ ХЯНАЛТЫН
ИТГЭМЖЛЭГДСЭН
БАЙГУУЛЛАГА-2
"ЦЭСБ Аудит" ХХК

“ТЕРМЕС ЦЕНТР” ХК-ИЙН 2018 ОНЫ НОГДОЛ АШИГ ХУВААРИЛЖ

ТАРААСАН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

“Термес центр” ХК нь 2018 оны эхний хагас жилд 461.4 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан. Үүнээс:

Компанийн ТУЗ-ийн 2018 оны 08-р сарын 31-ний өдрийн №02 тоот тогтоолын дагуу 2018 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас 392.7 сая төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгаар хуваарилахаар шийдвэрлэсэн. Нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийн хэмжээ 5 төгрөг байсан.

2018 оны 09-р сарын 10-ны бүртгэлийн өдрөөр нийт 910 хувьцаа эзэмшигчид байсан бөгөөд тэдгээрт оногдох ногдол ашгаас:

- 10 хувьцаа эзэмшигчдийн 67 364 717 ширхэг хувьцааны ногдол ашиг 336.8 сая төгрөгийг компанийн төв байран дээр бэлэн мөнгөөр,
- 900 хувьцаа эзэмшигчдийн 11 178 284 ширхэг хувьцааны ногдол ашиг 55.9 сая төгрөгийг Үнэт Цаас Төвлөрсөн Хадгаламжийн Төвтэй гэрээ байгуулж тараасан болно.

“Термес Центр” ХКомпанийн 2018 оны сүүлийн хагас жилийн аудитаар баталгаажсан цэвэр ашгийн хэмжээ 330.7 сая төгрөг байлаа. Үүнээс:

1. Компанийн ТУЗ-ийн 2019 оны 01-р сарын 25-ны өдрийн №02 тоот тогтоолын дагуу 2018 оны сүүлийн хагас жилийн цэвэр ашгаас 298.4 сая төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгаар хуваарилахаар шийдвэрлэсэн. Нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийн хэмжээ 3 төгрөг 80 мөнгө байсан.

2019 оны 02-р сарын 18-ны өдрийн бүртгэлийн өдрөөр нийт 911 хувьцаа эзэмшигчид байсан бөгөөд тэдгээрт оногдох ногдол ашгаас:

- 14 хувьцаа эзэмшигчдийн 67 507 749 ширхэг хувьцааны ногдол ашиг 256.5 сая төгрөгийг компанийн төв байран дээр бэлэн мөнгөөр,
- 897 хувьцаа эзэмшигчдийн 11 035 252 ширхэг хувьцааны ногдол ашиг 41.9 сая төгрөгийг Үнэт Цаас Төвлөрсөн Хадгаламжийн Төвтэй гэрээ байгуулж тараасан.

“ТЕРМЕС ЦЕНТР” ХК-ИЙН 2019 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН НОГДОЛ АШИГ

ХУВААРИЛЖ ТАРААСАН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

“Термес центр” ХК нь 2019 оны эхний хагас жилд 481.3 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан. Үүнээс:

Компанийн ТУЗ-ийн 2019 оны 08-р сарын 15-ны өдрийн №02 тоот тогтоолын дагуу 2019 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас 447.7 сая төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгаар хуваарилахаар шийдвэрлэсэн. Нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийн хэмжээ 5 төгрөг 70 мөнгө байсан.

2019 оны 09-р сарын 02-ны бүртгэлийн өдрөөр нийт 937 хувьцаа эзэмшигчид байсан бөгөөд тэдгээрт оногдох ногдол ашгаас:

- 11 хувьцаа эзэмшигчдийн 67 406 717 ширхэг хувьцааны ногдол ашиг 384.2 сая төгрөгийг компанийн төв байран дээр бэлэн мөнгөөр,
- 926 хувьцаа эзэмшигчдийн 11 136 284 ширхэг хувьцааны ногдол ашиг 63.5 сая төгрөгийг Үнэт Цаас Төвлөрсөн Хадгаламжийн Төвтэй гэрээ байгуулж тараасан болно.

Компанийн 2019 оны сүүлийн хагас жилийн аудитаар баталгаажсан цэвэр ашгийн хэмжээ 340.6 сая төгрөг байсан.

Компанийн ТУЗ-ийн 2020 оны 02-р сарын 05-ны өдрийн №02 тоот тогтоолын дагуу 2019 оны сүүлийн хагас жилийн цэвэр ашгаас 322.0 сая төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгаар хуваарилахаар шийдвэрлэсэн. Нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийн хэмжээ 4 төгрөг 10 мөнгө байсан.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2020 оны 02-р сарын 28-ны өдрөөр тасалбар болгож, ногдол ашгийг 2020 оны 03-р сарын 15-ны өдрөөс эхлэн олгохоор шийдвэрлэсэн.

“ГЕРМЕС ЦЕНТР” ХК-ИЙН 2020 ОНЫ НОГДОЛ АШГИЙН ТУХАЙ

”Гермес центр” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь уламжлал ёсоор 2020 онд хувьцаа эзэмшигчдийнхээ эрх ашгийг дээдэлж, 2020 оны санхүүгийн тайланд 2 удаа аудитын дүгнэлт гаргуулж, ногдол ашгийг оны хагас болон бүтэн жилээр хоёр удаа хуваарилах саналтай байгааг хувьцаа эзэмшигчдэдээ мэдэгдэхэд таатай байна.

“ГЕРМЕС ЦЕНТР” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ БОЛОН ГҮЙЦЭТГЭХ

ЗАХИРЛЫН 2019 ОНД ГАРСАН ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ЗАРДАЛ

1. ”Гермес центр” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь дараах зардлыг гаргаж зарцуулсан болно.
Үүнд :
 - Цалингийн зардал нийт 13.2 сая төгрөг
 - ТУЗ-ийн гишүүн нь хуралд оролцсон тохиолдолд нэг удаагийн 350 000.00 төгрөгийн цалин авдаг. Хуралд оролцоогүй тохиолдолд цалин олгодоггүй болно.
2. Компанийн гүйцэтгэх захирлын цалин урамшууллын зардалд нийт 58.3 сая төгрөг зарцуулсан.

“ГЕРМЕС ЦЕНТР” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ БОЛОН ГҮЙЦЭТГЭХ

ЗАХИРЛЫН 2020 ОНЫ ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ЗАРДЛЫН ТӨСӨВ

1. ”Гермес центр” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь 2020 онд дараах цалингийн санг өмнөх оны төсвөөр батлуулахаар Хувьцаа эзэмшигчдийн хуралд санал оруулж байна. Үүнд:
 - ТУЗ-ийн дарга хуралд оролцсон тохиолдолд нэг удаагийн 410 000 төгрөгийн цалин олгох – улиралд 1 удаа хуралдана
 - ТУЗ-ийн гишүүн хуралд оролцсон тохиолдолд нэг удаагийн 350 000 төгрөгийн цалин олгох – улиралд 1 удаа хуралдана
 - Цалингийн нийт зардал 4 улирлаар тооцоход 14.2 сая төгрөг
2. Компанийн Гүйцэтгэх захирлын цалин урамшууллын зардал 73.2 сая төгрөг байна.

“ГЕРМЕС ЦЕНТР” ХК-ИЙН НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭД БОЛОН ТЭДГЭЭРИЙН ЭЗЭМШИЛД БАЙГАА ХУВЬЦААНЫ ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

Компанийн нэр: “Гермес Центр” ХК

Компанийн гаргасан хувьцааны тоо: 78 543 001

Мэдээлэл гаргасан огноо: 2019 оны эхний хагас жилийн ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдөр буюу 2019 оны 09-р сарын 02-ны өдөр

№	Нэгдмэл сонирхолтой этгээдийн овог нэр	Эрхэлж буй албан тушаал	Эзэмшиж буй хувьцааны		
			Тоо ширхэг	Нийт хувьцаанд эзлэх хувь	Энэ хувьд хүрсэн огноо
1	Дашзэвэг овогтой Зоригт	Иргэн	42 530 145	54.10%	2019.09.02
2	Дугаржав овогтой Оюунсүрэн	"АСУ" сургуулийн захирал	23 460 015	29.80%	2019.09.02
Нийт			65 990 160	83.90%	

“ГЕРМЕС ЦЕНТР” ХК-ИЙН 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ

“Ая тухыг эрхэмлэгч” барилгын материалын худалдааны төв байх

- Нэгдүгээрт : Худалдан авагчдын эрх ашгийг дээдэлж, ая тухтай үйлчилж
- Хоёрдугаарт : Түрээслэгчдийн эрх ашгийг дээдэлж, тэднийг ажиллах нөхцлөөр хангаж
- Гуравдугаарт : Ажиллагсдын эрх ашгийг хамгаалж, нийгмийн асуудлыг шийдвэрлэж
- Дөрөвдүгээрт : Хувьцаа эзэмшигчдийн нэгж хувьцааны өгөөжийг нэмэгдүүлж ажиллана.

Компанийн орлогын тухай:

Тус компани нь 2020 оны эцэст 1 821.7 сая төгрөгийн цэвэр орлоготой ажиллана.

Компанийн зарлагын тухай

Компанийн хэмжээгээр 2020 онд төсөвлөснөөр 788.9 сая төгрөгийн зардалтай ажиллана.

Компанийн ашгийн тухай

Татварын дараах цэвэр ашиг төсөвлөснөөр 890.1 сая төгрөг байна.

Компанийн нэгж хувьцаанд хуваарилах ашгийн тухай

“Гермес центр” ХК-ийн нэгж хувьцаанд 11 төгрөг 33 мөнгөний ногдол ашиг оногдохоор төлөвлөсөн.

Компанийн бүтэц зохион байгуулалтын тухай

Компани нь 16 ажиллагсадтайгаар үйл ажиллагаагаа явуулна.

“ГЕРМЕС ЦЕНТР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

2020 оны 3-р сарын 20-ны өдөр

Дугаар 1

Улаанбаатар хот

Тооллогын дүнг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хууль, Компанийн дүрэмд заасны дагуу “Гермес Центр” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 03-р сарын 20-ны өдрийн хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрхтэй/...../ хувийн хувьцаа эзэмшигчид хүрэлцэн ирсэн тул тооллогын дүнг хавсралтын дагуу баталж, ээлжит хуралд танилцуулсугай.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА

Д.ОТГОНЧИМЭГ

ТООЛЛОГЫН КОМИССЫН ГИШҮҮН

Г.БАТЗОРИГ

Л.ОЮУНГЭРЭЛ

ГЕРМЕС ЦЕНТР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 3-р сарын 20-ны өдөр

Дугаар 1

Улаанбаатар хот

Тооллогын дүнг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хууль, Компанийн дүрэм болон ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь :

1. Хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрхтэй хувийн хувьцаа эзэмшигчид \хавсралт №1\ хүрэлцэн ирсэн тул хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцсугай.
2. Хурлын ирц хангалттай тул хувьцаа эзэмшигчдийн хурлыг хурлын дэгийн дагуу явуулахыг зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА

Д.ОЮУНСҮРЭН

“ГЕРМЕС ЦЕНТР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 3-р сарын 20-ны өдөр

Дугаар 2

Улаанбаатар хот

ТУЗ-ийн төсвийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 3-р сарын 20-ны өдрийн хурлын саналын хуудасны дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь :

1. “Гермес центр”ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн төсвийг хавсралтын дагуу баталсугай.
2. Энэхүү батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж ажиллахыг ТУЗ-ийн дарга /Д.Оюунсүрэн/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Аудитын хооро /Д.Туяа/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Д.ОЮУНСҮРЭН

**“ТЕРМЕС ЦЕНТР” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН 2020 ОНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ**

№	Зүйл анги	2020 оны төсөв			
		тоо	Нэгжийн нэг удаагийн зардал /₮/	Нийт нэг удаагийн зардал /₮/	Жилийн нийт зардал /₮/
	Цалин үүнд :				
1	ТУЗ-ийн дарга	1	410 000.00	410 000.00	1 640 000.00
2	Гишүүн	8	350 000.00	2 800 000.00	11 200 000.00
	Бүгд дүн				12 840 000.00

- Жич : ТУЗ-ийн гишүүн хуралд оролцсон тохиолдолд нэг удаагийн цалинг олгох бөгөөд улиралд 1 удаа хуралдахаар тогтсон болно. Хуралд ТУЗ-ийн гишүүн ямар нэгэн шалтгаанаар оролцоогүй тохиолдолд цалин олгогдохгүй.

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

[illegible]

Хурлын материалтай танилцсан эрхэм хүндэт хувьцаа эзэмшигч

Танд гүн талархал илэрхийлье.

“Гермес Центр”ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл